

АҮЭБЯ-НЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/22 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагаагаа эхэлсэн. Ёс зүйн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ёс зүйн дэд хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Ёс зүйн дэд хороонд 2026 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, гомдол 4 ирсэн.

Ёс зүйн дэд хороо нь 3 удаа хуралдаж 3 гомдолын асуудлаар дүгнэлт гарган томилох эрх бүхий этгээдэд хүргүүлсэн. 1 гомдол нь АМГТГ-ын албан хаагчтай холбоотой гомдол байсан тул АМГТГ-ын ёс зүйн дэд хороонд шилжүүлэн шийдвэрлэсэн.

Ёс зүйн дэд хороо албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн. Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд байгууллага, албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийсэн. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ёс зүйн дэд хорооны 2026 оны 1 дүгээр улиралд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан судалгаа, сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулах талаар яамны удирдлагуудад үүрэг өгч албан хаагчдын оролцоог бүрэн хангуулсан. Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооноос ирүүлсэн тогтоолуудыг Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанд тухай бүр хүргүүлсэн. Шинээр ажилд орсон ажилтнуудаас гаргасан байгууллагын соёлыг сайжруулахад анхаарах асуудлуудыг удирдлагын хуралд хэлэлцэж, шийдвэрлэх үүрэг өгч, хэрэгжсэн.

АҮЭБЯ-ны Ёс зүйн дэд хороо

Тайлан гаргасан:

АҮЭБЯ-ны Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Д.Батнайрамдал